



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/43

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн гэрээний загварыг
шинэчлэн батлах тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь хэсэг, Даргын зөвлөлийн 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн гэрээний загварыг хавсралтаар баталсугай.

2. Нийт ажилтан албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтсийн Дотоод ажил хариусан мэргэжилтэн Т.Түвшинзаяад үүрэг болгосугай.

3. Хөдөлмөрийн гэрээний хугацаанд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн П.Түвшинзаяад, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Нямхүүд тус тус даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600043